

2025 оны 03 сарын 19-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Г 7  
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ”

Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 80.2 дахь хэсгүүд, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ын 2018 оны 377 дугаар тогтоолыг заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавилга” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг Баянгол дүүргийн 16 дугаар хороо, Гандан, Энхтайвны өргөн чөлөө, 35/2 Шуудангийн гудамж Ramada/рамада/ зочид буудлын 4 дүгээр давхарын Кристал танхимд 2025 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 11 цагт хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсүгэй. Үүнд:

2.1. Тавилга ХК-ийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөрт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг нэгдүгээр хавсралтаар баталж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэх, мөн уг зарыг 2025 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин хурлын зар мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хоёрдугаар хавсралт, хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралт, саналын хуудсыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

5. Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын гишүүд, хурал даргалагч, тооллогын комиссын дарга, гишүүдэд дараах албан тушаалтныг тус тус томилсугай. Үүнд

1. Хурал даргалагч: Ц.Байгалмаа / Гүйцэтгэх захирал /
2. Хурал зохион байгуулах комиссын дарга: Ц.Баярмаа /Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн/
3. Хурал зохион байгуулах комиссын гишүүд: Х.Баяржаргал /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/
4. Тооллогын комиссын дарга: Н.Уранбилэг
5. Тооллогын комиссын гишүүн: Б.Сумъяабазар

6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 07-ний өдрөөр тогтоосугай.

7. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл түүнтэй холбогдох баримт бичгийг 2025 оны 03 дугаар сарын 26-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэх ажлыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

8. Тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийг удирдлага болгон ажилласугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БАНЗРАГЧ